



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Норовлин сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ХЭА-2022/116/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2022 он</p>	<p>Аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар Утас: 70562112</p> <p>Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390</p> <p>Аудитор: Х.Еркегүл Утас: 99040705</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
3. Аудитын тайлан .....	9
3.1 Ерөнхий зүйл .....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	9
3.4 Материаллаг байдал .....	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал .....	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	11
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	12
4. Аудитын илрүүлэлт .....	13
4.2.1 Залруулсан алдаа.....	13
4.2.2 Төлбөрийн акт .....	13
4.2.3 Албан шаардлага .....	13
4.2.4 Зөвлөмж.....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	14
6. Төлбөрийн акт .....	15

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12  
E-mail: [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn)

2022.03.07 № 100  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Норовлин сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Норовлин сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

023030135

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны кол	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэ	Эцсийн үлдэгд:
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>800,000.00</b>	<b>1,895,250.00</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
33	АВЛАГА	-	1,095,250.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	1,095,250.00
34	УРЬДЧИЛГАА	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	800,000.00	800,000.00
354	Хангамжийн материал	800,000.00	800,000.00
35420	Аж ахуйн материал	800,000.00	800,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>328,000.36</b>	<b>10,000.36</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	328,000.36	10,000.36
392	Биет хөрөнгө	328,000.36	10,000.36
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,195,498.00	3,195,498.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,867,497.64)	(3,185,497.64)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	390,720.00	390,720.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(390,720.00)	(390,720.00)
39301	Програм хангамж	30,000.00	30,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(30,000.00)	(30,000.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,128,000.36</b>	<b>1,905,250.36</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,128,000.36</b>	<b>1,905,250.36</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,128,000.36	1,905,250.36
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,110,000.00	1,110,000.00
51101	Өмч: - төрийн	1,110,000.00	1,110,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	(41,890.64)	735,359.36
51210	Өмнөх үеийн үр дүн	(41,890.64)	(41,890.64)
51220	Тайланг үеийн үр дүн	-	777,250.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	59,891.00	59,891.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,128,000.36</b>	<b>1,905,250.36</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>58,650,800.00</b>	<b>63,039,200.00</b>
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>58,650,800.00</b>	<b>63,039,200.00</b>
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>4,000,000.00</b>	<b>3,300,000.00</b>
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00	3,300,000.00
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>54,650,800.00</b>	<b>59,739,200.00</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	54,650,800.00	59,739,200.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>58,414,660.08</b>	<b>62,261,950.00</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>58,414,660.08</b>	<b>62,261,950.00</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>56,237,190.20</b>	<b>59,538,533.00</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>38,894,552.00</b>	<b>36,492,623.00</b>
Үндсэн цалин	38,894,552.00	36,492,623.00
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>4,654,155.12</b>	<b>5,281,460.00</b>
Тэтгэврийн даатгал	3,012,077.28	3,681,546.96
Тэтгэмжийн даатгал	338,907.72	300,529.04
ҮОМШӨ-ний даатгал	276,455.76	405,972.00
Ажилгүйдлийн даатгал	222,633.92	81,211.00
Эрүүл мэндийн даатгал	804,080.44	812,201.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,541,730.00</b>	<b>11,469,740.00</b>
Бичиг хэрэг	1,587,200.00	902,000.00
Тээвэр, шатахуун	4,354,530.00	10,456,520.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	111,220.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	-
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>100,000.00</b>	<b>576,000.00</b>
Дотоод албан томилолт	100,000.00	576,000.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,697,800.00</b>	<b>1,975,400.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,229,800.00	1,975,400.00
Аудит, баталгаа жуулалт, зэрэглэл тогтоох	468,000.00	-
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,348,953.08</b>	<b>3,743,310.00</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,294,000.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,789,854.00	1,131,310.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	559,099.08	318,000.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,177,469.88</b>	<b>2,723,417.00</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>180,000.00</b>	<b>1,125,000.00</b>
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	180,000.00	1,125,000.00
<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,997,469.88</b>	<b>1,598,417.00</b>
Төвлөрүүлэх шилжүүлэг	1,997,469.88	1,598,417.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>236,139.92</b>	<b>777,250.00</b>
<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>236,139.92</b>	<b>777,250.00</b>

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,110,000.00	59,891.00	(278,030.58)		891,860.42
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,110,000.00	59,891.00	(278,030.58)	-	891,860.42
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,110,000.00	59,891.00	(41,890.64)	-	1,128,000.36
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл		59,891.00	(41,890.64)	-	1,128,000.36
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,110,000.00	59,891.00	(41,890.64)	-	1,128,000.36
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	777,250.00		777,250.00
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,110,000.00	59,891.00	735,359.36	-	1,905,250.36

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>58,650,800.00</b>	<b>63,039,200.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>58,650,800.00</b>	<b>63,039,200.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	4,000,000.00	3,300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00	3,300,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	54,650,800.00	59,739,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	54,650,800.00	59,739,200.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>58,650,800.00</b>	<b>63,039,200.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>58,650,800.00</b>	<b>63,039,200.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>56,473,330.12</b>	<b>59,195,533.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	38,349,908.20	36,492,624.00
210101	Үндсэн цалин	25,829,472.00	21,950,827.00
210102	Нэмэгдэл	4,360,436.20	5,277,797.00
210104	Урамшуулал	8,160,000.00	9,264,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	5,138,037.92	5,281,459.00
210201	Тэтгэврийн даатгал	3,577,937.92	3,600,459.00
210202	Тэтгэмжийн даатгал	392,100.00	420,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	313,500.00	336,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	79,700.00	84,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	774,800.00	840,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,497,700.00	4,901,440.00
210401	Бичиг хэрэг	616,000.00	608,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,537,700.00	4,182,220.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	164,000.00	111,220.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	180,000.00	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	100,000.00	576,000.00
210702	Дотоод албан томилолт	100,000.00	576,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,392,630.00	3,860,050.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлгэж ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,068,630.00	3,860,050.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,995,054.00	8,083,960.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	6,562,650.00
210902	Хинчээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,995,054.00	1,521,310.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,177,469.88</b>	<b>3,843,667.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	180,000.00	1,150,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	180,000.00	1,150,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	1,997,469.88	2,693,667.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,997,469.88	2,693,667.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>-</b>	<b>-</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-</b>	<b>-</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>-</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	59,739,200.00	58,140,783.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	59,739,200.00	58,140,783.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	58,572,600.00	56,990,783.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	37,552,400.00	36,492,624.00
210101	Үндсэн цалин	21,331,000.00	21,950,827.00
210102	Нэмэгдэл	6,922,900.00	5,277,797.00
210104	Урамшуулал	9,298,500.00	9,264,000.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	5,673,900.00	5,281,459.00
210201	Тэтгэврийн даатгал	3,992,800.00	3,600,459.00
210202	Тэтгэмжийн даатгал	420,300.00	420,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	336,200.00	336,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	84,100.00	84,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	840,500.00	840,500.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,910,100.00	4,901,440.00
210401	Бичиг хэрэг	516,500.00	608,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,205,000.00	4,182,220.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	188,600.00	111,220.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	689,800.00	576,000.00
210702	Дотоод албан томилолт	689,800.00	576,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,852,200.00	3,848,050.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	3,852,200.00	3,848,050.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5,894,200.00	5,891,210.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,372,200.00	4,369,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,522,000.00	1,521,310.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,166,600.00	1,150,000.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,166,600.00	1,150,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,166,600.00	1,150,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	59,739,200.00	58,140,783.00
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	59,739,200.00	58,140,783.00
132001	Орон нутгийн төсвөөс	59,739,200.00	58,140,783.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,300,000.00</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,204,750.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,204,750.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,192,750.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,192,750.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,095,250.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	1,095,250.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,300,000.00</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,300,000.00

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Норовлин сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркегүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Норовлин сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 07 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Сумын ИТХ нь орон нутагт Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлж, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг бэхжүүлэх чиг үүрэгтэй үйл ажиллагаа явуулдаг, орон нутгийн харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Норовлин сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

#### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн

тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 58.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 0.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 0.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Норовлин сумын ИТХ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 0.8 сая төгрөгөөр буюу 68.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь авлагын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1.0	2.0	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	1,095.3	1,095.3
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	800.0	800.0	-
Үндсэн хөрөнгө	328.0	10.0	(318.0)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,128.0</b>	<b>1,905.3</b>	<b>777.3</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын сан /Орон нутгийн сан	1,110.0	1,110.0	-
Өмнөх үеийн үр дүн	(41.9)	(41.9)	-
Тайлант оны үр дүн		777.3	777.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	59.9	59.9	-
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,128.0</b>	<b>1,905.3</b>	<b>777.3</b>
<b>Нийт орлого /Үр дүнгийн тайлан</b>	<b>58,650.8</b>	<b>63,039.2</b>	<b>4,388.4</b>
<b>Нийт зардал /Үр дүнгийн тайлан</b>	<b>56,237.2</b>	<b>59,538.5</b>	<b>3,301.3</b>

Авлага дансны үлдэгдэл 1.1 сая төгрөг болж өссөн нь нэмэлт дансны санхүүжилтийн данснаас жилийн эцэст төвлөрүүлсэн орлогыг авлагаар тусгасантай байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 0.3 сая төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан элэгдлийн дүн байна.

Засгийн газрын сан дансны үлдэгдэл 1.1 сая төгрөг байна. Тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 63.0 сая төгрөг болж, өмнөх оноос 4.4 сая төгрөгөөр буюу 7.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт өссөн байна.

Нийт зардал 59.5 сая төгрөг болж, өмнөх оноос 3.3 сая төгрөгөөр буюу 5.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь тээвэр, шатахууны зардал байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тайлант онд орон нутгийн төсвөөс 59.7 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд орон нутгийн төсвөөс 59.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үүнээс урсгал үйл ажиллагаанд 58.1 сая төгрөгийг зарцуулж, 1.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Төсвийн гүйцэтгэл 97.3 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тухайн байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ИТХ-аас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 3.3 сая төгрөгийн санхүүжилт орж, үүнээс урсгал үйл ажиллагааны зардалд 2.2 сая төгрөг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 1.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт хамааралтай асуудал илрээгүй.

### **3.8 Аудитын гол асуудал**

Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч 276.0 мянган төгрөгийн томилолт олгосон зөрчил илэрсэн.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд 28,388.4 мянган төгрөгийн 4 орлогын гүйлгээг бүрэн мэдээлжээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны аудитаар 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн ба хэрэгжилт 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал бүртгэгдээгүй.

#### **4. Аудитын илрүүлэлт**

---

Аудитаар нийт 1.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1.1 сая төгрөгийн алдааг залруулж, 0.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

##### **4.2.1 Залруулсан алдаа**

Нэмэлт санхүүжилтийн дансны төвлөрүүлсэн үлдэгдлийг авлагаар тусгаагүй зардалд хаасныг санхүүгийн тайланд зарлуулав.

##### **4.2.2 Төлбөрийн акт**

Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч 276.0 мянган төгрөгийн томилолт олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоов.

##### **4.2.3 Албан шаардлага**

Албан шаардлага хүргүүлээгүй.

##### **4.2.4 Зөвлөмж**

Зөвлөмж өгөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Хэнтий аймгийн Норовлин сумын ИТХ	1	1.4	1	1.1	1	0.3				
<b>Дүн</b>		<b>1</b>	<b>1.4</b>	<b>1</b>	<b>1.1</b>	<b>1</b>	<b>0.3</b>				
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Хэнтий аймгийн Норовлин сумын ИТХ	0	0								
<b>Дүн</b>		<b>0</b>	<b>0</b>								
<b>Нийт дүн</b>		<b>1</b>	<b>1.4</b>	<b>1</b>	<b>1.1</b>	<b>1</b>	<b>0.3</b>				



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 01/А2370449  
ХЭА-2022/116/НА-ГА-ТШЗ

Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Норовлин сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Анхан шатны баримтын бүрдэлгүй 276.0 мянган төгрөгийн томилолт олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” Гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь::

1. ИТХ-аас анхан шатны баримтыг бүрдүүлээгүй олгосон 276.0 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь “Нэр заагдаагүй бусад орлого” 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх
2. Актын биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Норовлин сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Б.Тунгалагмөрөнд хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЕРКЕГҮЛ

Д.ОЮУНТУЯА